



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

Тамхины хор хөнөөлийн талаарх
нөлөөллийн аяныг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1095 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Түншлэл-үйлчилгээний соёлыг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 91, 94 дүгээр сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдын дунд хүүхдийн хүмүүжил төлөвшил, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй тамхины хор хөнөөлийн талаар ойлгуулах, мэдлэг олгох “**No smoke**” нөлөөллийн аяныг 2025 оны 03 дугаар сарын 24-өөс 04 дүгээр сарын 19-ийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Аянд зарцуулагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 600,000 (Зургаан зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг дүүргийн менежер (Г.Дагвадорж)-т, аяныг чанар, үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 29-ий өдрийн дотор Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн
А/65 дугаар захирамжийн хавсралт



**“NO SMOKE” НӨЛӨӨЛЛИЙН АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ**

д/д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	2 дугаар байр	1	300,000	300,000	300,000
2	Тусгай байр	2	100,000	200,000	200,000
3	Өргөмжлөл, жааз	5	20,000	100,000	100,000
Дүн					600,000